



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 06/20

Улаанбаатар хот

«Эмнэлгийн бүтэц, орон тоог батлах тухай»

Эрүүл мэндийн тухай хуулийн 14, 15, 17 дугаар зүйлийн 17.1, 17.7 дахь заалт, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйл, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төвийн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төвийн бүтэц, орон тоог төвийн удирдлагын багаас боловсруулсан хөгжлийн төлөвлөгөөний дагуу шинэчлэн баталсугай.
2. Тус төвийн нэн шаардлагатай үндсэн болон гэрээт ажилчдийг бүтэц, орон тооны өөрчлөлтийн дагуу, шат дараалалтай нэмэгдүүлэн ажиллахыг Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төвийн гүйцэтгэх захирал Ц.Уранчимэгт даалгасугай.
3. Тус төвийн бүтэц, орон тооны өөрчлөлтийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төвийн гүйцэтгэх захирал Ц.Уранчимэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ЭНХЗАЯА

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ

/Орон тоо-154/

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2020 ойн 16 сарын 17 өдөр
01/00/0011/2017/АХС
дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧИГ

Гүйцэтгэх захирал

ЭМНЭЛ ЗҮЙ ЭРХЭЛСЭН
ДЭД ЗАХИРАЛ

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН
ДЭД ЗАХИРАЛ

ЭМТҮЧАБ АЛБА

ЭМ ЗҮЙН АЛБА

СУРГАЛТЫН АЛБА

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЛБА

ХҮНИЙ НӨВЧИЙН АЛБА

ХСХ АЛБА

СУВИЛАХУЙН АЛБА

СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨЛТИЙН АЛБА

САНХҮҮ БҮРТГЭЛИЙН АЛБА

АЖ АХУЙН АЛБА

ПОЛИКЛИНИКИЙН ТАСАГ

ЭМЧИЛГЭЭНИЙ ГОО ЗАСАЛ,
НӨХӨН СЭРГЭЭХ ТАСАГ

ХҮЛЭЭН АВАХ, ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ,
ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСАГ

ЛАБОРАТОРИЙН ТАСАГ

ХАРШИЛ СУДЛАЛЫН
ЛАБОРАТОРИ


НАСАНД ХҮРЭГЧДИЙН
АРЬС, ХАРШЛЫН I ТАСАГ

НАСАНД ХҮРЭГЧДИЙН АРЬС,
ХАРШЛЫН II ТАСАГ

ХҮҮХДИЙН АРЬС, ХАРШЛЫН ТАСАГ

ЭМЧИЛГЭЭНИЙ ХООП
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАСАГ

"АВАРГА ТОСОН"
КЛИНИК СУВИЛАЛ



Төлөөлөн удирдах зөвлөлийн
2020 оны 06 сарын 17 өдрийн
05/20 ДУГААР ТОГТООЛЫН
2 ДУГААР ХАВСРАЛТ

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ОРШИЛ

Арьсны өвчин судлалын үндэсний төв нь Улсын хэмжээнд арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээг амбулатори болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах чиг үүрэг бүхий лавлагаа шатны төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэг юм.

Үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд арьс харшлын өвчнийг оношлох, эмчлэх, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээг зохион байгуулах, стандарт, удирдамж, аргачлал боловсруулах, төгсөлтийн дараах сургалт эрхлэх, олон нийтэд мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх, олон улсын байгууллага, өндөр хөгжилтэй орнуудтай хамтран ажиллах зэрэг олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Арьс-харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах зорилгоор 2003 оноос сургалт-эрдэм шинжилгээ эрхэлсэн албатай болж, улсын хэмжээнд арьсны өвчин судлалын чиглэлээр мэргэшүүлэх сургалт явуулан, олон улсын эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулж байна. Мөн харшлын оношилгооны аллерген болон вакцин үйлдвэрлэж, тэдгээрийн нэр төрлийг олшруулан, технологийг илүү сайжруулахыг зорьж байна.

НЭГ. АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Хүн амын дундах ажилгүйдэл, ядуурал, эрүүл мэндийн боловсролын хангалтгүй байдал, эрүүл бус хооллолт, орчны бохирдол зэрэг олон сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл нь эрүүл ахуйн шалтгаант харшлын гаралтай арьсны эмгэгүүд ихсэхэд нөлөөлж, тулгамдсан асуудал болсоор байна.

Тухайлбал: 2018 онд ургамлын харшлын эмгэг 4680, хоол хүнсний харшлын эмгэг 3320 тохиолдол илэрсэн нь урд оноос өссөн үзүүлэлт юм.

Ойрын ирээдүйд хүн амын арьсны эрүүл мэндийн шинэ эрэлт хэрэгцээнд суурилан тусламж, үйлчилгээний хүрээг өргөтгөх, мэс заслын тусламж үйлчилгээг нэвтрүүлэх, хөдөө орон нутгийн эмч, мэргэжилтний арьс-харшлын өвчний оношилгоо, эмчилгээний мэдлэг, ур чадварыг түлхүү хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага өндөр байна. Үүнд:

1.1. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг 8 их эмч, 24 сувилагч, 4 тасаг, 170 ортойгоор үзүүлж сүүлийн 5 жилийн дунджаар 5534 өвчтөнийг эмчилсэн. Орны хүчин чадлаа бүрэн ашиглавал жилд дунджаар 7130 хүн хэвтүүлэн эмчлэх боломжтой. Нөөцөө бүрэн ашиглаж чаддаггүйн улмаас жилд 30-35 ор буюу нэг тасаг сул ажиллаж, алдагдсан боломжийн зардал 415 сая төгрөгийн орлого олох боломжоо алдаж, тухайн өртгийн төвтэй холбогдох зардал үр ашиггүй зарцуулагдаж байна.




Мөн 2019 онд эрүүл мэндийн даатгалын сангаас хэвтүүлэн эмчлэх нэг өвчтөнд дунджаар 255 мянган төгрөгийн санхүүжилт авч, 330 мянган төгрөгийн өртөг, зардал зардал гарч, нэг өвчтөний эмчилгээний зардлаас 75 мянган төгрөг, нийт 410 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Статистик үзүүлэлт



Хэвтүүлэн эмчлэх нэг өвчтөний орлого, зарлагын тэнцэл /мянга төг



1.2. Амбулаторийн тусламж, үйлчилгээ

Амбулаторийн тусламж, үйлчилгээг 11 их эмч, 3 сувилагч, 7 асрагч, нийт 27 ажилтан, 11 кабинетаар арьс, арьсны харшлын өвчнийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх байдлаар сүүлийн 5 жилийн дунджаар 83312 хүнд үзүүлсэн. Нэг эмчид ноогдох үзлэгийн тоо 30-35 хүн. Амбулаторийн эмч нарын ачаалал өндөр, нөөц бололцоогоо 130% давуулан ажилладаг. Жил ирэх тутам арьсны өвчлөл нэмэгдэж байгаа үед нөөцийн хувиарлалт буруу хийгдэх нь алдагдсан боломжийн зардлыг 161 сая төгрөгөөр өсгөх үзүүлэлт болж байна.



Мөн 2019 онд амбулаторийн тусламж үйлчилгээгээр эрүүл мэндийн даатгалын сангаас нэг өвчтөнөөс 15 мянган төгрөгийн санхүүжилт авч, 9 мянган төгрөгийн өртөг зардал гарч 6 мянган төгрөгийн ашиг 500 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.



Дүгнэлт : Хэвтүүлэн эмчлэх 170 орны нөөцөө бүрэн ашиглаж чадвал алдагдсан боломжийн зардал буурч, нэг өвчтөнийг хэвтүүлэх эмчлэх өртөг багасч алдагдал хүлээхгүй. Гэтэл арьсны өвчлөл болгон хэвтүүлэн эмчлэх заалттай өвчлөл байдаггүй тул цаашид хэвтүүлэн эмчлэх хүний тоо өсөхгүй, сул орны эргэлт их, нэгж өвчтөнд ноогдох өртөг өндөр гарсаар байна. Иймээс амбулатори, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний зохистой харьцааг бүрдүүлэх, эхний ээлжинд хэвтүүлэн эмчлэх нэг тасгийг татан буулгаж, нөөцөө зөв хувиарлан, амбулаторийн кабинетийн тоог тэргүүлэх 5 өвчлөлийн хүрээнд төрөлжүүлж, өвчтөнд суурилсан нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх боломжийг судлан, төлөвлөлт хийх. Ингэснээр хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээнээс дунджаар 308 мянган төгрөгийн санхүүжилт олж, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний өртөг 363 мянган төгрөг болж нэг өвчтөний эмчилгээний зардлаас 55 мянган төгрөгийн алдагдал хүлээнэ. Цаашид хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний тоог бууруулж амбулаторийн тусламж үйлчилгээний хүртээмжээ нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн нэмэлт үйлчилгээний өртгийн төвүүдийн зардлыг бууруулах үүднээс хоол үйлвэрлэлийн тасгийг түрээслэх, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг үзүүлэхээс өмнө шаардлагатай оношлогоо, шинжилгээг хийсэн байх, харуул хамгаалалтыг бусдаар гүйцэтгүүлэх зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.



1.3. Хүлээн авах, яаралтай тусламж, үйлчилгээ, эрчимт эмчилгээ

Хүлээн авах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг иргэдэд үзүүлдэг 4 санхүүжилтээ нэхэмжлэх эрх зүйн зохицуулалт байдаггүй. Эрүүл мэндийн даатгалын сангаас хүлээн авах, яаралтай тусламж үйлчилгээний зардлыг нэхэмжлэх боломжгүй тул өртөг нь үр ашиггүй зардал болж, эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээний зардлыг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний өртгөөр нэхэмжилдэг. Гэтэл эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээ өөрөө өртөг, зардал өндөр байдаг нь байгууллагын хувьд алдагдал болж, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний нэг өвчтөнд ноогдох өртгийн хэмжээг өсгөхөд нөлөөлж байна. 2019 онд эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээнээс 15 сая төгрөгийн алдагдал хүлээсэн.

Эрчимт эмчилгээний эмч байхгүй тул тасаг нээн ажиллуулах боломжгүй. Арьсны зарим өвчлөл биеийн 60%-иас дээш хэмжээг хамарсан тууралттай бол эрчимт эмчилгээ хийх заалт болдог. Нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 20% нь дээрх заалттай хэвтдэг боловч тууралт амь насанд халтай /90-100%/, амьсгал боогдсон үед л эрчимт эмчилгээний өрөөнд хэвтүүлэн, шаардлагатай арга хэмжээг авч, амь насны эрсдэл холуур өнгөрсөн үед тасагт шилжүүлэн эмчилдэг. Иймээс эрчимт эмчилгээний эмч сургаж, бэлтгэх шаардлагатай.

Дүгнэлт: Хагас бие даасан байдалд шилжсэнээр, улсын төсвөөс зардлыг нь төр хариуцах хүлээн авах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээний зардлаа нэхэмжлэх боломжтой болж, энэ төрлийн тусламж, үйлчилгээнээс алдагдал хүлээхгүй нөхцөл бүрдсэн. Нийт хэвтүүлэн эмчлүүлэгчдийн 20% нь эрчимт эмчилгээний тасагт хэвтүүлэн эмчлэгдэх заалтыг хангасан байдаг. Иймээс хүлээн авах, яаралтай тусламж үйлчилгээ, эрчимт эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

1.4. Мэс заслын тусламж, үйлчилгээ

Төвийн арьсны гоо засал, нөхөн сэргээх тасагт арьсны гоо заслын мэс заслын жижиг ажилбар хийгддэг боловч, арьсны хавдар, бусад идээт үрэвсэл, буглаа нээх жижиг мэс ажилбар хийдэг эмч байхгүй.

Арьсны мэс засалд улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн дунджаар 6546 хүн орсон. Арьсны идээт ба мөөгөнцөрт өвчнүүд, целлулит, лимфаденит оношоор мэс заслын тусламж үйлчилгээг жилд дунджаар 3000 хүнд хийдэг. Бид нөөц боломжоо ашиглан нийт мэс заслын 5%-г кабинетаар хийх боломжтой.

Дүгнэлт: Мэс заслын нэгжийн тоог нэмэгдүүлэх, боловсон хүчнээ сургаж бэлтгэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах судалгаа, тооцоолол хийх.

1.5. Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээ

2019 онд өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээг 1 эмч, 1 сувилагч, 20 ортойгоор үзүүлж 323 хүн эмчилсэн. Энэ тусламж, үйлчилгээний өртөг дунджаар 94.6 мянган



төгрөг, эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилт дунджаар 63.1 мянган төгрөг, нэг өвчтөнөөс 21.5 мянган төгрөг нийт 6.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.



Дүгнэлт: Өдрийн эмчилгээ нь алдагдалтай ажиллаж байгаа харагдавч энэ эмчилгээг хийснээр дагах орлого буюу амбулаторийн эмчилгээ, амбулаторийн сувиллагчийн үйлчилгээний орлого нэмэгддэг. Мөн өвчтөнийг хэвтүүлэн эмчлэхгүйгээр өдрийн эмчилгээнд шилжүүлсэн хүний тоогоор хүлээж буй алдагдалын хэмжээ буурч ашигтай ажиллаж эхлэнэ. Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний өртөг өндөр, алдагдал хүлээж байгаа үед өдрийн эмчилгээгээр тусламж үйлчилгээ үзүүлэх нь илүү оновчтой.

1.6. Зайн оношлогоо

Хөдөө орон нутаг, гадны улс оронд байгаа, ирж үзүүлэх боломжгүй хүмүүст алсын зайн оношлогоо хийдэг. Бид энэ үйлчилгээг 2019 онд 6 хүнд үзүүлсэн боловч оношлогоог одоогоор төлбөргүй үзүүлж байна. Зайн оношлогооны өртөг дунджаар 9 мянган төгрөг, орлого дунджаар 20 мянган төгрөг, алдагдсан боломжийн зардал 66 мянган төгрөг.

Дүгнэлт: Алсын зайн оношлогооны тусламж үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай хөрөнгө мөнгийг шийдвэрлэх, төлбөрийг нэгдсэн дансанд төвлөрүүлж авдаг болох судалгаа тооцоолол хийх.



ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛ, ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

АЛСЫН ХАРАА:

ЭРҮҮЛ АРЬС-ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ

ЭРХЭМ ЗОРИЛГО:

ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРСЭН АРЬС-ХАРШИЛ, ЭМЧИЛГЭЭНИЙ ГОО ЗАСЛЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЧАНАРТАЙ, ШУУРХАЙ, АЮУЛГҮЙ ҮЗҮҮЛЭХ

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС:

- *Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж-Бидний итгэл, найдвар*
- *Үйлчлүүлэгчийн арьсны эрүүл мэнд- Бидний чанарын баталгаа*
- *Үйлчлүүлэгчийн эдгэрэлт –Бидний дэвшил, хөгжил*
- *Үйлчлүүлэгчийн инээмсэглэл-Бидний ёс зүй, хариуцлага*

БИДНИЙ ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

- *Зөв хандлага, хүндлэлд суурилсан соёлтой*
- *Үйл явц нь хэрэгцээнд суурилсан, оновчтой*
- *Гүйцэтгэл нь үр дүнтэй, үр ашигтай*
- *Тусламж, үйлчилгээ нь аюулгүй, чанартай*
- *Хүний нөөц чадварлаг, мэдрэмжтэй*
- *Хагас бие даасан тогтолцоотой*

БИДНИЙ ӨДӨР ТУТАМ МӨРДӨХ ДҮРЭМ:

- *Алсын хараа, эрхэм зорилгоо дээдлэнэ.*
- *Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллана.*
- *Арьс харшил, эмчилгээний гоо заслын эрэлт хэрэгцээнд тулгуурлана.*
- *Тасралтгүй суралцагч байгууллага байж, Үндэсний хэмжээний арьс харшил, гоо заслын эмч, мэргэжилтэнг чанартай бэлтгэнэ.*
- *Тусламж, үйлчилгээ нь шинэ санаа, шинэ мэдлэг, дэвшилтэт технологи, нотолгоонд суурилна.*
- *Мэргэшсэн өндөр чадавхитай багаар ажиллан, шилдэг үйлчилгээг хүргэнэ.*
- *Удирдлага, хамт олны манлайлал, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагыг эрхэмлэнэ.*

ГУРАВ. СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ, ЗОРИЛГО, ЗОРИЛТ

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 1. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ



Стратегийн зорилго 1. Үйлчлүүлэгчдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэх

Стратегийн зорилт 1.1.1. Үйлчлүүлэгчдэд арьс харшлын өвчнөөс сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх

Стратегийн зорилт 1.1.2 Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээний үр дүнг сайжруулах

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Стратегийн зорилго 2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

Стратегийн зорилт 2.1.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх

Стратегийн зорилт 2.1.2 Хүлээн авах, яаралтай тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, бүтэц, тусламж, үйлчилгээг сайжруулах

Стратегийн зорилт 2.1.3. Чанарын удирдлагын тогтолцоо, арга хэрэгслийг сайжруулан, тасралтгүй байдлыг хангах

Стратегийн зорилт 2.1.4. Арьсны өвчний сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, сувилгаа, асаргааны үр дүнг дээшлүүлэх

Стратегийн зорилт 2.1.5. Эмнэлгийн халдвар, хамгаалал, ариутгалын аюулгүй байдлыг хангах

Стратегийн зорилт 2.1.6. Аюулгүй, эрсдэлгүй тусламж, үйлчилгээг үзүүлэх

Стратегийн зорилт 2.1.7. Үйлчлүүлэгчид, ажилчдын аюулгүй байдлыг хангаж, дэмжлэгт орчныг бүрдүүлэх

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

Стратегийн зорилго 3.1.Тасралтгүй суралцагч байгууллага байж, зөв хандлагад суурилсан хүний нөөцийг хөгжүүлэх

Стратегийн зорилт 3. 1.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр чадварлаг мэргэшсэн хүний нөөцөөр хангах

Стратегийн зорилт: 3.2.1. Хүний нөөцийн байршил, хангамжийг оновчтой болгож, бие даасан байдлыг хангах

Стратегийн зорилт: 3.1.3. Эрдэм судлал, судалгаа-шинжилгээг хөгжүүлэх

Стратегийн зорилт 3.1.4. Гүйцэтгэлийн удирдлагын оновчтой тогтолцоог нэвтрүүлэх

Стратегийн зорилт 3.1.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёл, хариуцлагыг дээшлүүлэх

Стратегийн зорилт 3.1.6. Хүний нөөцийн нийгмийн баталгааг сайжруулах



СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 4. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТ

Стратегийн зорилго 4.1 Тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлтэй нягт уялдуулан, санхүүжилтийн тогтолцоог шинэчлэн, үр ашгийг дээшлүүлэх

Стратегийн зорилт 4.1.1. Эдийн засгийн үр ашиг, өртгийн тооцоолол хийж, санхүүгийн удирдлагыг оновчтой болгох

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ

Стратегийн зорилго. 5.1. Дэвшилтэт технологийн нэвтрэлтийг хангаж, тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан, хүрээг өргөтгөх

Стратегийн зорилт 5.1.1. Хүн амын арьсны эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх

Стратегийн зорилт 5.1.2. Дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангаж, засвар үйлчилгээний тасралтгүй байдлыг сайжруулах

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 6. ЭМ ЗҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

Стратегийн зорилго 6.1. Эм зүйн үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг ханган, зохистой хэрэглээг төлөвшүүлэх

Стратегийн зорилт 6.1.1 Клиникийн эм зүйн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх

Стратегийн зорилт 6.1.2 Арьс харшил, эмчилгээний гоо заслын эм, био бэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 7: МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН УДИРДЛАГА

Стратегийн зорилго 7.1. Мэдээллийн технологийн нэвтрэлтийг хангаж, цахим эмнэлэг болох

Стратегийн зорилт 7.1.1. Цахим технологийг нэвтрүүлэн, цахим эмнэлэг болох

СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ 8. БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Стратегийн зорилго 8.1 Байгууллагын хөгжил, удирдлага зохион байгуулалт, ил тод байдлыг хангах

Стратегийн зорилт 8.1.1. Хагас бие даасан засаглалыг хөгжүүлэх

Стратегийн зорилт 8.1.2. Байгууллагын удирдлага, зохион байгуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэн, ил тод байдлыг хангах

Стратегийн зорилт 8.1.3. Хэрэглэгч төвтэй, сэтгэлд шингэсэн, үйлчилгээ үзүүлэх



Стратегийн зорилт 8.1.4. Төрөлжсөн мэргэшлээр Улсын хэмжээнд лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэн мэргэжил арга зүйгээр хангаж, арьс харшил, эмчилгээний гоо заслын мэргэжилтэн бэлтгэх

Стратегийн зорилт 8.1.5. Төр хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэн, гадаад харилцааг хөгжүүлэх

ДӨРӨВ. ХҮРЭХ ҮР ДҮН

- 4.1. Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааны үр дүн, чанар, хүртээмж нэмэгдэж, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн боловсрол сайжирна.
- 4.2. Арьс харшил, эмчилгээний гоо сайхны тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, чанар, хүртээмж сайжирч, хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.
- 4.3. Чадварлаг, мэргэшсэн хүний нөөцөөр хангагдаж, бүтээмж нэмэгдэж, нийгмийн баталгаа сайжирна.
- 4.4. Байгууллагын төсвийн орлого, зардлын үр ашиг нэмэгдэн, санхүүгийн удирдлага оновчтой болно.
- 4.5. Дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж нэвтэрч, хүн амын арьсны эрүүл мэндийн шинэ эрэлт, хэрэгцээ хангагдана.
- 4.6. Эм зүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжран, эмийн зохистой хэрэглээ төлөвшинэ.
- 4.7. Шинэ, дэвшилтэт мэдээллийн технологийн нэвтрэлт хангагдан, цахим эмнэлэг болно.
- 4.8. Хагас бие даасан засаглалтай болж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн сайжирч, нээлттэй, ил тод байдал хангагдана.

ТАВ. ҮР НӨЛӨӨ

- 5.1. Арьс харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээг олон улсын түвшинд үзүүлж, хүн амын арьсны эрүүл мэнд сайжирч, сэтгэл ханамж дээшилнэ.
- 5.2. Хагас бие даасан засаглал хөгжиж, байгууллагын үр дүн, үр ашгийн тогтвортой байдал хангагдана.

ЗУРГАА. САНХҮҮЖИЛТ

- 6.1. Стратегийг хэрэгжүүлэх санхүүжилтийг стратегийн чиглэл, үйл ажиллагаа бүрээр тооцоолон, эх үүсвэрийг нарийвчлан тусгана.
- 6.2. Стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилт нь дараах эх үүсвэртэй байна.
 - 6.2.1 Улсын төсөв
 - 6.2.2 Гадаадын хандив, тусламж, төсөл хөтөлбөр
 - 6.2.3 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт
 - 6.2.4 Төр, хувийн хэвшлийн түншлэл
 - 6.2.5 Өөрийн орлого, бусад эх үүсвэр



ДОЛОО. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

- 7.1. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын үнэлгээг жил бүр, хөндлөнгийн үнэлгээг 2 жилд нэг удаа хийнэ. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх загвар, аргачлал, шалгуур үзүүлэлтийг тусгайлан боловсруулж, шаардагдах зардлыг төсөвт тусган, хэрэгжилтийг хангаж ажиллана. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлд тухай бүр танилцуулан, нэмэлт өөрчлөлтийн талаар хэлэлцэн, шийдвэрлэнэ.
- 7.2. Стратеги төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахдаа хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжид үндэслэн, нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай нь нотлогдсон, улс, салбарын эдийн засаг, төсөв, санхүүгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулна.

НАЙМ. ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЧИГЛЭЛЭЭ

Бид зорьж буй алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараах стратегийн чиглэлийг 2020 онд тэргүүлэх ач холбогдолтой хэмээн тодорхойлж байна.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1: ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Зорилго 1.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

<i>Хэрэгжүүлэх стратеги 1. Амбулатори, хэвтэн эмчлүүлэгчийн зохистой харьцааг бүрдүүлэх</i>
<i>Хэрэгжүүлэх стратеги 2. Яаралтай тусламжийн тасаг, эрчимт эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээний тасаг нээж үйлчилгээг хүртээмжтэй болгох.</i>
<i>Хэрэгжүүлэх стратеги 3. Мэс заслын кабинет тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх</i>
<i>Хэрэгжүүлэх стратеги 4. Өдрийн эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх</i>
<i>Хэрэгжүүлэх стратеги 5. Лабораторийн оношлогоо, шинжилгээний тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, дархлаа дэмжих эмчилгээний хүртээмжийг сайжруулах</i>
<i>Хэрэгжүүлэх стратеги 6. Амбулаторийн эмчилгээ, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх</i>
<i>Хэрэгжүүлэх стратеги 7. Арьсны гоо засал, нөхөн сэргээх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх</i>

Үр дүнг хэмжих үзүүлэлтүүд	Өнөөдрийн түвшин	Зорилтод түвшин
----------------------------	------------------	-----------------



<p>Шалгуур үзүүлэлт 1:</p> <p>Амбулаторийн эмч, сувилагч, асрагч нарын тоо, кабинетийн тоо</p>	<ul style="list-style-type: none">➢ Кабинет-11➢ Эмч-11➢ Резидент эмч-тойргоор➢ Сувилагч-2➢ Асрагч-3➢ Амбулаторийн үзлэгийн тоо-83312	<ul style="list-style-type: none">➢ Мэс засал, хавдар кабинет-1➢ Арьсны кабинет- 4➢ Харшлын кабинет-3➢ Хүүхдийн кабинет-2➢ Хамуу, мөөгөнцөр кабинет-1➢ Эмч- 12➢ Резидент эмч-8➢ Сувилагч-3➢ Асрагч-7➢ Амбулаторийн үзлэгийн тоо- 91460
<p>Шалгуур үзүүлэлт 2:</p> <p>Хэвтүүлэн эмчлэх тасгийн эмч, сувилагч, асрагч нарын тоо, тасгийн тоо</p>	<ul style="list-style-type: none">➢ Нийт тасаг-4➢ Эмч-8➢ Резидент эмч тойролтоор➢ Сувилагч-24➢ Асрагч-8➢ Орны тоо - 170➢ Хэвтэн эмчлүүлэгчийн тоо- 5500	<ul style="list-style-type: none">➢ Нийт тасаг-3➢ Эмч-6➢ Резидент эмч-6➢ Сувилагч-21➢ Асрагч-6➢ Орны тоо - 140➢ Хэвтэн эмчлүүлэгчийн тоо- 5000
<p>Шалгуур үзүүлэлт 3:</p> <p>Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний нэгжийн тоо, эмч, сувилагч, асрагч нарын тоо</p>	<ul style="list-style-type: none">➢ Яаралтай тусламж-1➢ Эрчимт эмчилгээний нэгж -1➢ Эрчимт эмчилгээ орны тоо-2➢ Эмч /тасгийн эмч нар ээлжилж ажилладаг/➢ Сувилагч-1	<ul style="list-style-type: none">➢ Яаралтай тусламж-1➢ Эрчимт эмчилгээний нэгж-1➢ Эрчимт эмчилгээ орны тоо-4➢ Эмч-3➢ Сувилагч -5➢ Асрагч-2
<p>Шалгуур үзүүлэлт 4 :</p> <p>Мэс заслын кабинетийн тоо, эмч, сувилагч, асрагч нарын тоо</p>	<ul style="list-style-type: none">➢ Мэс заслын кабинет-1	<ul style="list-style-type: none">➢ Мэс заслын кабинет-2➢ Эмч- 1➢ Сувилагч-1➢ Асрагч -1➢ Тусламж үйлчилгээ үзүүлэх хүн- 50
<p>Шалгуур үзүүлэлт 5:</p> <p>Өдрийн эмчилгээний кабинет, эмч, сувилагч, эмчлүүлэгчийн тоо</p>	<ul style="list-style-type: none">➢ Кабинет - 1➢ Эмч-1➢ Сувилагч-1➢ Өдрийн эмчилгээ хийлгэсэн өвчтөний тоо-	<ul style="list-style-type: none">➢ Кабинет – 1➢ Эмч-1➢ Сувилагч-1➢ Өдрийн эмчилгээ хийлгэсэн өвчтөний



	323	тоо- 500
<p>Шалгуур үзүүлэлт 6:</p> <p>Лабораторийн оношлогоо, шинжилгээний нэр төрөл, шинжилгээ хийлгэсэн хүний тоо, эмч, лаборангийн тоо</p>	<ul style="list-style-type: none">➢ Эмч-3➢ Лаборант -6➢ Ариутгагч-2➢ Асрагч-1➢ Оношлогоо шинжилгээний төрөл - 19➢ Оношлогоо шинжилгээ хийлгэсэн хүний тоо- 17,655	<ul style="list-style-type: none">➢ Эмч-4➢ Лаборант -6➢ Ариутгагч-2➢ Асрагч-1➢ Оношлогоо шинжилгээний төрөл - 21➢ Оношлогоо шинжилгээ хийлгэсэн хүний тоо- 18,000
<p>Шалгуур үзүүлэлт 7:</p> <p>Харшил судлалын лабораторийн ажилтаны тоо, үйлдвэрлэсэн харшлын сорил, вакцины тоо</p>	<ul style="list-style-type: none">➢ Биологич-1➢ Ургамал зүйч -1➢ Био химич -1➢ Үйлдвэрлэсэн вакцины тоо-470➢ Үйлдвэрлэсэн харшлын сорил тоо – 10 багц /1багц 200-250 хүн/	<ul style="list-style-type: none">➢ Биологич-1➢ Ургамал зүйч -1➢ Био химич -1➢ лаборант- 1➢ Үйлдвэрлэсэн вакцины -350➢ Үйлдвэрлэсэн харшлын сорил тоо- 10 багц /1багц 200-250 хүн/
<p>Шалгуур үзүүлэлт 8:</p> <p>Амбулаторийн эмчилгээ үйлчилгээний сувилагч тоо, эмчилгээ үйлчилгээний тоо</p>	<ul style="list-style-type: none">➢ Сувилагч- 2➢ Вакцины тоо-417➢ Сорил тавиулсан хүний тоо –205➢ Плазмаферез-➢ Аутоплазм эмчилгээний тоо -223➢ Сувилахуйн тусламж үйлчилгээний тоо- 7444	<ul style="list-style-type: none">➢ Сувилагч-2➢ Вакцины тоо-330➢ Сорил тавиулсан хүний тоо –221➢ Плазмаферез-➢ Аутоплазм-эмчилгээний тоо- 300➢ Сувилахуйн тусламж үйлчилгээний тоо- 9000
<p>Шалгуур үзүүлэлт 9:</p> <p>Эмчилгээний гоо засал, нөхөн сэргээх тасгийн эмч, сувилагч, асрагч, эмчилгээ үйлчилгээний тоо</p>	<ul style="list-style-type: none">➢ Эмч -4➢ Сувилагч- 6➢ Асрагч-1➢ Эмчилгээний гоо заслын эмчилгээний нэр төрөл - 16	<ul style="list-style-type: none">➢ Эмч- 4➢ Сувилагч- 6➢ Асрагч-1➢ Эмчилгээний гоо заслын эмчилгээний нэр



	<ul style="list-style-type: none"> ➢ Нөхөн сэргээх эмчилгээний нэр төрөл-21 	<p>төрөл-18</p> <ul style="list-style-type: none"> ➢ Нөхөн сэргээх эмчилгээний нэр төрөл -25
Шалгуур үзүүлэлт 10: Эмч сонгох үйлчилгээ нэвтрүүлэх	<ul style="list-style-type: none"> ➢ Нэвтрээгүй 	<ul style="list-style-type: none"> ➢ Эмч нарын тоо -29 ➢ Үйлчлүүлэгчдийн тоо- 1000

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

Зорилго 2.1.Тасралтгүй суралцагч байгууллага байж, зөв хандлагад суурилсан хүний нөөцийг хөгжүүлэх

Хэрэгжүүлэх стратеги 1. Шинэ хэрэгцээнд суурилан хүний нөөцийг төлөвлөн сургах

Хэрэгжүүлэх стратеги 2. Эрдмийн болон мэргэжлийн зэрэг хамгаалахад дэмжлэгт удирдлагаар хангах, үр нөлөөллийг нэмэгдүүлэх

Хэрэгжүүлэх стратеги 3. Төрөлжүүлэн мэргэшүүлэх, сэлгэн ажиллах тогтолцоог бүрдүүлэх

Үр дүнг хэмжих үзүүлэлтүүд	Өнөөдрийн түвшин	Зорилтод түвшин
Шалгуур үзүүлэлт 1: Мэс засал, эрчимт эмчилгээний эмч, сувилагч	<ul style="list-style-type: none"> ➢ Мэс заслын эмч-1 ➢ Эрчимт эмчилгээний эмч-0 ➢ Сувилагч-1 	<ul style="list-style-type: none"> ➢ Мэс заслын эмч- 2 ➢ Эрчимт эмчилгээний эмч-1 ➢ Сувилагч-2
Шалгуур үзүүлэлт 1: Нийт ажилчдын дунд эрдмийн болон мэргэжлийн зэрэг хамгаалсан ажилчдын хувь	<ul style="list-style-type: none"> ➢ Нийт ажилчдын- 44.7% 	<ul style="list-style-type: none"> ➢ Нийт ажилчдын- 60% хүргэх



ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТЕХНОЛОГИ

Зорилго 3.1 Хүн амын арьсны эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд суурилсан дэвшилтэт төнхологийг нэвтрүүлэх

Хэрэгжүүлэх стратеги 1. Цахим хэрэгсэл, дэвшилтэд технологи ашиглаж хөдөө орон нутгийн эмч нарыг мэргэжил арга зүйгээр хангах, сургах

Хэрэгжүүлэх стратеги 2. Дэвшилтэт технологиор оношилгоо хийх

Үр дүнг хэмжих үзүүлэлтүүд	Өнөөдрийн түвшин	Зорилтод түвшин
<p>Шалгуур үзүүлэлт 1:</p> <p>Цахим хэрэгсэл, дэвшилтэт технологи ашиглаж сургалт, арга зүйгээр хангасан эмч нарын тоо</p>	<ul style="list-style-type: none"> ➢ Аймаг- 15 ➢ Эмч-48 ➢ Танхимын сургалт- 120 эмч 	<ul style="list-style-type: none"> ➢ Аймаг – 21 ➢ Эмч – 60 ➢ Танхимын сургалт- 150 эмч
<p>Шалгуур үзүүлэлт 2:</p> <p>Теледемицин алсын зайн оношлогоонд хамгардсан хүний тоо</p>	<ul style="list-style-type: none"> ➢ Хөдөө орон нутаг – 2 ➢ Гадаад улс орон – 4 	<ul style="list-style-type: none"> ➢ Хөдөө орон нутаг – 20 ➢ Гадаад улс орон – 10

Дөрөв.Төлөвлөгөөний удирдлага ба санхүүжилт, хяналт үнэлгээ

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт, гарч буй үр дүнд үнэлгээ өгч, хүндрэл, бэрхшээл, тасалдлыг арилгаж, хэрэгжих таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Хяналт-шинжилгээ, үнэлгээг төлөвлөгөөний бүлэг, дэд бүлэг бүрт багтсан тэргүүлэх зорилтуудын хүрээнд тусгасан үзүүлэлтүүдийг үндэслэн хийнэ.

4.1 Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ерөнхий зарчим

4.1.1 Стратеги төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг зохион байгуулахдаа арга зүйн болон мэдээллийн нэгдсэн байдлыг хангах.

4.1.2 Стратеги төлөвлөгөөний эцсийн үр дүнг үнэлэхдээ удирдлагын багын гишүүдээс бүрдсэн хяналт шалгалтын баг үнэлгээ хийнэ.

4.2 Хяналт-шинжилгээ, хугацаа

4.2.1.Стратеги төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслүүдийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн хөгжлийн төлөвлөгөөний зорилго, зорилт арга хэмжээ, хэрэгжүүлэх хугацаанаас хамааран тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэнэ.

4.2.2. Удирдлагын шатлал бүрт өөрийн харъяалах нэгжийн үйл ажиллагаанд хяналтыг тавьж ажиллана.



4.2.3 Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээний үр дүн, цаашид авах арга хэмжээний саналын хамт удирдалын багаас томилсон хяналтын баг ТУЗ хурлаар хэлэлцүүлнэ.

4.3 Эрсдлийн удирдлага

Эрсдлийн удирдлага нь тавьсан зорилгодоо бүрэн хүрэх, тэдгээрээс гарах үр дүнг дээшлүүлэхэд дэмжлэг болох хэрэгсэл бөгөөд эрсдлээ тодорхойлох, шинжлэх, үнэлэх, эрсдлийн харьцааг тогтоох зэрэг үргэлжилсэн үйл ажиллагаа юм.

Хөгжлийн төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх явцад тодорхой эрсдэл үүсэж болзошгүй учир тэдгээрийг тооцож, урьдчилан сэргийлэх, засан залруулах арга хэмжээ авах шаардлага тулгардаг.

Тэргүүлэх чиглэл 1: Эмнэлэгийн тусламж, үйлчилгээ

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний өвчтөний тоог бууруулсан ч тухайн үйлчилгээнээс алдагдал хүлээнэ. Амбулаторийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж чадвал хэвтүүлэн эмчлэх тасаг нэгжийн тоог үе шаттайгаар бууруулсанаар энэ тусламж үйлчилгээнээс хүлээх алдагдал буурч чадна гэж үзэж байгаа. Мөн эмчилгээг өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээр хүргэх нь илүү эрсдэл багатай арга хэрэгсэл болно. Гэвч амбулаторийн эмч нарын тоог нэмэгдүүлэхгүйгээр хүртээмжийг нэмэгдүүлэхээр зохион байгуулалт хийх нь шинэ арга барилд эмч нарын дасан зохицох, төлөвлөх, зэрэг үйл ажиллагааны алдаа дутагдлаас үйлчилгээний тоо төлөвлөснөөс багасах эрсдэлтэй байна.

Тэргүүлэх чиглэл 2: Хүний нөөцийн хөгжил

Тэргүүлэх энэ чиглэлээр ямар нэгэн эрсдэл хүлээхгүй гэж үзэж байна.

Тэргүүлэх чиглэл 3: Эрүүл мэндийн технологи

Тэргүүлэх энэ чиглэлээр ямар нэгэн эрсдэл хүлээхгүй гэж үзэж байна.



ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

д/д	Үйл ажиллагаа	Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт	Улсын төсвийн санхүүжилт	/сая төгрөг/ Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих
1	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний өртөг	1,965.1		
2	Амбулаторийн тусламж, үйлчилгээний өртөг	1,231.1		315.7
3	Оношлогоо шинжилгээний өртөг	775.2		45.8
4	Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж үйлчилгээний өртөг		391.2	
5	Өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээний өртөг	76.7		
6	Эмчилгээний гоо засал, нөхөн сэргээх эмчилгээний өртөг			200.3
7	Амбулаторийн эмчилгээ, сувилалын үйлчилгээний өртөг			84.9
9	Амбулаторийн нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардагдах урсгал засварын өртөг		200	
10	Мэс засал, эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, хүүхдийн эмч, сувилагч бэлтгэх, арьсны эмгэг, эд судлаач эмч, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах өртөг			10.0
11	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		93.1	
12	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх			21.8
13	Гүйцэтгэлийн үнэлгээгээр ажилчдыг дүгнэж урамшуулах өртөг			236.9
	Нийт дүн= 5.649.7	4050.0	684.3	915.4